



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20<sup>21</sup> он  
сарын 17 өдөр

Дугаар 31-2/684

Улаанбаатар  
хот

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Г.ТЭМҮҮЛЭН ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Таны 2021 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн УИХ-03/6550 дугаар албан бичгээр тавьсан асуулгад дараахь хариуг хүргүүлж байна. Үүнд:

**Асуулга 1.** “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн хэрэгжилт

**Хариулт 1.** Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль нь газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, түүхий тос дамжуулах хоолой барих үйл ажиллагаанд төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан бөгөөд энэхүү дэмжлэгийг үзүүлэх харилцааг нарийвчлан тодорхойлсон журам батлах үүргийг тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т зааснаар Засгийн газарт хүлээлгэсэн. Энэхүү журмыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас боловсруулан 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар батлуулж, тус хуулийг хэрэгжүүлэх арга замыг тодорхой болголоо.

Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх буюу газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах болон түүхий тос дамжуулах хоолой барих үйл ажиллагаатай холбоотой олон тулгамдсан асуудал байгаа хэдий ч Монгол Улсын Засгийн газар өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төслийн ажлыг бүхий л талаар дэмжиж, удирдлага, зохицуулалтаар хангаж, дотооддоо бензин шатахуунаа үйлдвэрлэх стратегийн зорилтыг биелүүлэхээр хүчин чармайлт гарган ажиллаж байна.

**Асуулга 2.** “Газрын тос боловсруулах үйлдвэрийн” төлөвлөгөөт ажлын явц

**Хариулт 2.** Төслийн өдөр тутмын үйл ажиллагааг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг БНЭУ-ын Экспорт-Импортын (Эксим) банк, төслийн

000021403651

менежментийн зөвлөх компанитай зөвшилцөж дор дурдсан 4 хэсэгт хуваан хэрэгжүүлж байна. Үүнд:

**ЕРС-1:** Технологийн бус барилга байгууламж;

**ЕРС-2:** Анхдагч процессын болон дагалдах байгууламж;

**ЕРС-3:** Үйлдвэрийн цахилгаан станц;

**ЕРС-4:** Лицензит технологийн байгууламж;

**ЕРС-1** ажлын хүрээнд үйлдвэрийн усан хангамжийн байгууламжууд, оффис, гал команд, хоолны газар, лаборатори, агуулах, засварын цех, анхны тусламжийн барилгууд, үйлдвэрийн талбайд зам, сувагчлал, үерийн ус зайлуулах систем зэрэг технологийн бус барилга байгууламжуудын барилга угсралтын бэлтгэлийг 2021 оны 1 дүгээр сараас хангаж, газар шорооны ажлын ухмалын хэсэг бүрэн дуусаж, суурийн хэв хашмал, арматурчлалын ажил, ус дамжуулах хоолой, авто зам, цахилгаан дамжуулах агаарын шугамын газар шорооны ажлууд үргэлжилж байна.

Үйлдвэрийн иргэний барилга байгууламжууд болох угтах байр-1, угтах байр-2, лаборатори, анхны тусламжийн төв, хоолны газар, оффис, сургалтын төв, агуулах, засварын цех, гал унтраах ангийн барилгын зураг төслийн ажил нь 86%-ийн гүйцэтгэлтэй, барилга угсралтын ажил хянагдсан зураг төслийн дагуу 20%-тай үргэлжилж байгаа бөгөөд газар шорооны ажил бүрэн дуусаж, бүтээцийн ажлууд явагдаж байна. Үйлдвэрийн технологийн усыг Бор хөөврийн говиос хангахаар шийдвэрлэсний дагуу 11 худаг, 100м<sup>3</sup>-ын ус цуглуулагч сав, ус дамжуулах 88 км урттай хоолой, өргөх насос станцын ажил 17%-ийн гүйцэтгэлтэй, үйлдвэрийн талбайд байрлах 30000м<sup>3</sup> багтаамжтай усан сангийн барилгын ажил 20%-ийн гүйцэтгэлтэй хийгдсэн.

Үйлдвэрийн зам талбайн үерийн ус зайлуулах суваг шуудуу болон цуглуулах савны газар шороо, сувагчлалын суурь бетоны ажил 50%-ийн гүйцэтгэлтэй байна. Төслийн талбайд 2021.07.30-ны өдрийн байдлаар төслийн менежментийн зөвлөх компанийн 5, "JMC Projects India" компанийн 121 энэтхэг, дотоодын туслан гүйцэтгэгч 8 компанийн 280 монгол ажилчид тус тус ажиллаж байна.

**ЕРС-2** ажлын хүрээнд үйлдвэрийн анхдагч процессын болон дагалдах байгууламжууд, үйлдвэрийн хангамжийн системийг барьж байгуулах юм. Ажлын ерөнхий гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулах тендерийг 2021.04.13-нд зарласан бөгөөд энэ оны 08 дугаар сард багтаан хүлээн авахаар ажиллаж байна.

**ЕРС-3** ажлын багцийн хүрээнд үйлдвэрийн 35 МВт хүчин чадалтай 2 ширхэг уурын генератор, 17,5 МВт-ын 2 ширхэг уурын турбин бүхий шингэн түлшээр ажиллах цахилгаан станцыг барьж байгуулах юм. Ажлын ерөнхий гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулах тендерийг 2021.05.20-нд зарласан бөгөөд энэ оны 09 дүгээр сард багтаан хүлээн авахаар ажиллаж байна.

**ЕРС-4** ажлын багцад лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил багтаж байгаа. Дэлхийд алдартай цөөн хэдэн компаниуд газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн байгууламжуудын лицензийг эзэмшдэг. Лиценз эзэмшигчдээс ирүүлсэн тендерийн техникийн хэсгийг хянах, үнэлэх ажил эцсийн

шатанд явагдаж байгаа бөгөөд техникийн шаардлага хангасан тендерийн үнийн саналыг нээх ажил эхлээд явж байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэг хэсэг болох үйлдвэрийн ажилчдын 550 айлын хотхоны эхний ээлжийн орон сууцны барилга угсралтын ажил 90%-тай. Ковид-19 цар тахлаас үүдсэн хөл хорио бүтээн байгуулалтын ажилд сөргөөр нөлөөлж байгаа хэдий ч урин дулаан улирлыг бүрэн ашиглаж, үйлдвэрийн болон хотхоны бүтээн байгуулалтын ажлыг тасралтгүй явуулах үүднээс боломжтой бүхий л арга хэмжээг авч байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах бүтээн байгуулалтын ажлын нэг хэсэг болох боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах Дорнод аймгийн Матад сумаас, Дорноговь аймгийн Алтанширээ сум дахь үйлдвэрийн байршил хүртэлх 560 орчим километр түүхий тос дамжуулах хоолой байгуулах төслийн ажлыг эхлүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар “Түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах” Үнэлгээний хороог байгуулж, мэргэжил, санхүүгийн чадавхтай олон улсын компаниудыг тендерт оролцуулах зорилгоор урьдчилсан сонголтын урилгын зарыг АНУ-ын “Gulf Publishing” компанийн “Pipeline and Gas Journal” сэтгүүл болон олон улсын газрын тосны сайтуудад нийтлүүлсэн. Урьдчилсан сонголтод 9 улсын 22 компани оролцох хүсэлтээ ирүүлснээс бидний тавьсан нөхцөл, шаардлагыг хангаж, хамтран ажиллах хүсэлт ирүүлсэн 15 компанид тендерт оролцох урилга, тендерийн баримт бичгийг 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр хүргүүлсэн. Тендер шалгаруулалтын материал ирүүлэх эцсийн хугацааг 2021 оны 08 сарын 23-ны өдрөөр тогтож, сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангаж байна.

**Асуулга 3.** Ерөнхий сайдын 2020 оны 32 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн танилцуулга, мэдээлэл;

**Хариулт 3.** Ерөнхий сайдын 2020 оны 32 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хийж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 15 зүйлээр Шадар сайдын 2020 оны 94 дүгээр тушаалаар баталсан. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийг арга хэмжээ бүрээр гаргаж, Төрийн ордонд 2021 оны 8 дугаар сарын 3-ны өдөр зохион байгуулсан ажлын хэсгийн хуралд танилцуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцээд Шадар сайдаас дараахь үүрэг даалгаврыг ажлын хэсгийн гишүүдэд өгсөн. Үүнд:

1. Тяньжин, Эрээн боомтоор ачаа барааг шуурхай татан авах талаар Засгийн газраас шийдвэр гарч, Улсын онцгой комисст чиглэл өгөгдсөний дагуу үйлдвэрийн төслийн тоног төхөөрөмж, бараа материалын татан авалтыг нэн тэргүүнд дараалал харгалзахгүй оруулах талаар ажлын хэсгийн гишүүд, нарийн бичгийн дарга, компанийн төлөөлөл хамтран ажиллах;

2. Дамжуулах хоолойн төсөлд Засгийн газрын баталгаа гаргах асуудлыг ойрын хугацаанд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

3. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Гадаад хэргийн яам, Газрын тос болон байгалийн хийн яамтай төслийн үйл ажиллагаа болон хоёр талын хамтын ажиллагааг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах, уул уурхай, газрын тосны салбарт Монгол Улсын Засгийн газар болон БНЭУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг боловсруулж санамж бичиг байгуулах бэлтгэл ажлыг хангах;

4. Ерөнхий гүйцэтгэгч Зэвсэгт хүчний 339 дүгээр анги, туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны 2 дугаар ээлжийн барилгын ажлыг эрчимжүүлэх, төлөвлөгөөний дагуу 2021 оны 9 сард ашиглалтад оруулах;

5. Төслийн ерөнхий болон туслан гүйцэтгэгч компаниудын бараа, ажил үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлөх асуудлын хүрээнд Сангийн сайдын 2021 оны 26 дугаар тушаалаар батлагдсан татвар, хураамжаас чөлөөлөгдөх жагсаалтад багтсан компаниудын талаар Гаалийн болон, Татварын байгууллагууд анхаарч ажиллах;

6. Ус ашигласны төлбөрөөс чөлөөлөхтэй холбоотой асуудлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам шийдвэрлэх зэрэг үүрэг даалгавар өгөгдсөн.

Хавсралт: 9... хуудастай.

Монгол Улсын Шадар сайд



С.АМАРСАЙХАН



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2020 оны 8 дугаар  
сарын 21-ний өдөр


Дугаар 32

Улаанбаатар  
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

У-2-05 ✓

1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулж, явцыг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Я.Содбаатар)-т даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Ерөнхий сайдын 2020 оны 32 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Урьдчилсан

Ажлын хэсгийн ахлагч

Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар

Ажлын хэсгийн Дэд ахлагч

-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд  
Г.Ёндон

Гишүүд:



-Сангийн сайд Ч.Хүрэлбаатар;

-Хууль зүй, дотоод хэргийн сайд  
Х.Нямбаатар;

-Батлан хамгаалахын сайд  
Г.Сайханбаяр;

-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд  
Д.Сарангэрэл;

-Гадаад харилцааны сайд Н.Энхтайван;

-Барилга, хот байгуулалтын сайд  
Б.Мөнхбаатар;

-Боловсрол, шинжлэх ухааны сайд  
Л.Цэдэвсүрэн;

-Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар;

-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд  
А.Ариунзаяа;

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
дэд дарга Б.Энх-Амгалан;

-Дорнод аймгийн Засаг дарга  
М.Бадамсүрэн;

-Сүхбаатар аймгийн Засаг дарга  
Ж.Эрдэнэбаатар;

-Дорноговь аймгийн Засаг даргын үүрэг  
гүйцэтгэгч Г.Эрдэнэцэцэг;

-Шадар сайдын ахлах зөвлөх  
С.Янжиңсүрэн;

-Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн;


-Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн;

-“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг.

Нарийн бичгийн дарга



-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Анхбаяр.



Ерөнхий сайдын 2020 оны 32 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт

Ажлын хэсэг нь үйл ажиллагаандаа дараахь удирдамжийг мөрдөнө:

1. Бүтээн байгуулалтын ажил эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын өнөөгийн байдал, байгуулсан гэрээ, хэлэлцээр, барилга зугсралтын ажлын төлөвлөлт, тулгамдсан болон шийдвэрлүүлэх зайлшгүй шаардлагатай асуудлын хүрээнд боловсруулж батлах;

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг хангах ажлыг хариуцсан чиглэл бүрээр шуурхай, хариуцлагатай зохион байгуулж, ажлын уялдаа хөлбоог сайжруулан, газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулах нэгдсэн удирдлагаар ханган, зохион байгуулалтын арга хэмжээ авч, хяналт тавьж, явцыг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллах.

---o0o---





# МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 20 оны 09 дугаар  
сарын 01 -ны өдөр

Дугаар 94

Улаанбаатар  
хот



Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 32 дугаар Захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд багтаан ашиглалтад оруулахтай холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлын хэсгийн хийж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Ажлын хэсгийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, төлөвлөгөөний биелэлтийн талаар тогтмол мэдээллээр хангаж ажиллахыг Шадар сайдын ахлах зөвлөх С.Янжинсүрэнд үүрэг болгосугай.

Монгол Улсын Шадар сайд



Я.СОДБААТАР

АЖЛЫН ХЭСГИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Хариуцах гишүүн	Хугацаа	Хүрэх үр дүн
1	Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ыг гүйцэтгэхээр шалгарсан БНЭУ-ын компанитай гэрээ байгуулж, бүтээн байгуулалтыг эхлүүлэх ажлыг зохион байгуулах	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг	2020 оны 9 дүгээр сар	Гэрээ байгуулсан байна.
2	Түүхий тос дамжуулах хоолой барих төслийн санхүүжилтийг гадаад, дотоод эх үүсвэрээс шийдвэрлэх талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон	2020 оны 9 дүгээр сар	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулсан байна.
3	Монгол Улсын Засгийн газрын гадаад улстай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж буй газрын тос боловсруулах үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд багтаан барьж байгуулахтай холбогдуулан тус төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, зохицуулалтын хүрээнд хууль, тогтоомжийн төсөл, санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх.	Ажлын хэсгийн гишүүд	2020 оны 11 дүгээр сар	Тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.
4	Тус төслийн ерөнхий гүйцэтгэгч Энэтхэгийн талын боловсруулсан барилга байгууламжийн төлөвлөлт, зураг төсөл, норм дүрэмтэй холбоотой англи хэл дээрх баримт бичгийг хүлээн авах, батлах ажлыг зохион байгуулах	Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг	2020 оны 9 дүгээр сар	Зураг төслийг баталсан байна.

5	Үйлдвэрийн бүтээн байгуулалттай холбоотойгоор олгосон газрыг газрын төлбөрөөс чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх	Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт	2020 оны 9 дүгээр сар	Холбогдох шийдвэр гарсан байна.
6	Үйлдвэрийн бүтээн байгуулалтад оролцогч ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч талуудыг бүх төрлийн татвар, төлбөр, хураамжаас чөлөөлөх асуудлыг судлан холбогдох тооцоо, судалгааг гарган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон	2020 оны 10 дүгээр сар	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.
7	Үйлдвэрийн бүтээн байгуулалтад оролцох гадаадын мэргэжилтэн, инженер, техникийн ажилчдад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөр болон визний хураамжаас чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар	2020 оны 9 дүгээр сар	Холбогдох шийдвэр гарсан байна.
8	БНЭУ-ын Гадаад хэргийн яам, Газрын тос, байгалийн хийн яамтай газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт болон хоёр талын хамтын ажиллагааг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах	Гадаад харилцааны сайд Н.Энхтайван	2020 12 дугаар сар	Ажлыг зохион байгуулсан байна.
9	Үйлдвэрт шаардлагатай инженер, техникийн болон туслах ажилчдыг сургах, дадлагажуулах чиглэлээр гадаад, дотоодын их, дээд сургуулиудад урт, богино хугацааны сургалтад хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	Гадаад харилцааны сайд Н.Энхтайван, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Боловсрол, шинжлэх ухаан, спортын сайд Л.Цэдэвсүрэн	2020 оны 9 дүгээр сар	Үйлдвэрт шаардлагатай боловсон хүчнийг холбогдох сургалтуудад хамруулсан байна.
10	Газрын тосны хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж, нөөцийг өсгөх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, БХГ-ний дагуу үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдэд	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн, бүх	2020 оны 12 дүгээр сар	Ажлыг зохион байгуулсан байна.

	холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх	шатны Засаг дарга нар		
11	Газрын тосны олборлолтыг тогтвортой хадгалах, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх, олборлолтыг батлагдсан орд ашиглах төлөвлөгөөнд тусгагдсан хэмжээнд хүргэх талаар "Петрочайна Дачин Тамсаг ХХК"-тай хэлэлцэх.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн	2020 оны 9 дүгээр сар	Уулзалт зохион байгуулж, хэлэлцээ хийсэн байна.
12	Газрын тос боловсруулах үйлдвэр, газрын тос дамжуулах хоолойн үндсэн, дагалдах байгууламжийн ашиглалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотой норм, дүрэм, журам, стандартын төслийг боловсруулж, батлах.	Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Стандарт хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн	2020-2024 он	Барилга, байгууламжийн норм, дүрэм, журам, стандартын төслийг боловсруулж, баталсан байна.
13	Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий эдийг тээвэрлэх дамжуулах хоолойн трассыг нарийвчлан тогтоож, трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулах.	Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг	2020 оны 10 дугаар сар	Трассыг тогтоож, улсын тусгай хэрэгцээнд авсан байна.
14	Газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх ажлыг зохион байгуулах.	Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг	2020 оны 9 дүгээр сар	Хотхоны бүтээн байгуулалтын ажил эхэлсэн байна.
15	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн Бор хөөврийн говийн гүний усны ордоос ациглах усны хэмжээнд ногдох улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрөөс чөлөөлөх, барилга угсралт бүтээн байгуулалтын үед ашиглах усыг усны төлбөрөөс чөлөөлөх, цаашид	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл	2020 оны 9 дүгээр сар	Үйлдвэрт шаардлагатай ус ашиглах дүгнэлт гаргасан байна.

	газрын тос боловсруулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн процессод ашиглах усны дүгнэлтийг гаргах ажлыг зохион байгуулах.			
--	---	--	--	--

---000---